

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

**ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ**

2026 он

Агуулга

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	3
ХОЁР.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОХ	3
ГУРАВ.ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООХ.....	4
3.1.Зорилгод хүрэх байдал	5
3.1.1.Зорилгыг тодорхойлох	5
3.1.2.Зорилгод хүрэх байдалд дүн шинжилгээ хийх.....	5
Дүгнэлт	7
3.2.Практикт хэрэгжих боломж	8
3.2.1.Хэрэгжүүлэгч субъект, институцийн чадавх	8
Дүгнэлт	9
3.3.Ойлгомжтой байдал.....	9
3.4.Зардал	10
3.5.Харилцан уялдаа	10
4.Үр нөлөөний үнэлгээний эцсийн дүгнэлт	10

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал” /цаашид “Аргачлал” гэх/-ыг баримтлан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /цаашид “Төсөл” гэх/-ийн үр нөлөөг үнэлэв. Тус үнэлгээг дараах үе шаттайгаар хийсэн болно. Үүнд:

- Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоох;
- Шалгуур үзүүлэлтэд тулгуурлан үр нөлөөг тооцох;
- Үр дүнг үнэлэх.

ХОЁР.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОХ

Аргачлалын 2 дугаар зүйлийн 2.2, 2.9-д заасны дагуу хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан үр нөлөөг 5 шалгуураар үнэлэх шаардлагатай гэж үзэв.

1.Зорилгод хүрэх байдал: Хуулийн төсөлд тусгасан зохицуулалт болон зорилго нь тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох, зорилгод хүрэх байдалд дүн шинжилгээ хийх тул хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

Тодруулбал, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай болгох, шүүхийн ачааллыг бууруулах үндсэн зорилгодоо хүрч чадах эсэхийг тус шалгуураар тогтооно.

2.Практикт хэрэгжих боломж: Хуулийн төсөлд практикт хэрэгцээ, шаардлагатай байгаа хэд хэдэн зохицуулалтуудыг тусгасан бөгөөд тэдгээр зохицуулалтууд нь хэрэгжих боломжтой эсэхийг тодруулах шаардлагатайг харгалзан үзэж тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

Жишээлбэл, шүүхийн албан ёсны цахим хуудсаар нэхэмжлэгч, хариуцагчид мэдэгдэх хуудас хүргүүлэх болон бусад процессууд техникийн болон бодит байдлын хувьд хэрэгжих боломжтой эсэхийг уг шалгуур үзүүлэлтээр тогтооно.

3.Ойлгомжтой байдал: Хуулийн зохицуулалт нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг.

Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүйн болон найруулга зүйн хувьд тодорхой, ойлгоход хялбараар томъёологдсон байх шаардлагатай.

Энэхүү хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

4.Зардал: Хуулийн төсөлд шинээр тусгасан зохицуулалтуудыг хэрэгжүүлэхэд иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагаас гарах мөнгөн зардлыг тооцох, хуулийн төслийн үйлчлэлд хамаарах этгээдэд ачаалал үүсэх эсэхийг тогтоох шаардлагатайг харгалзан зардал тооцох шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

5.Харилцан уялдаа: Хуулийн төслийн эх бичвэр нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой мөн төсөлд тусгагдсан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилгүй байх, хуулиар үүрэг хүлээсэн этгээдүүдийн чиг үүрэг, давхардал зөрчилдөөнгүй байх шаардлагатай.

Иймд хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан агуулгын шаардлагыг хангасан эсэхийг шалгах зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонголоо.

ГУРАВ.ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООХ

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэх хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо.

Хүснэгт-1

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн холбогдох зохицуулалтууд	Хуулийн төслийн үзэл баримтлал болон иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн долдугаар ¹ бүлэгт заасан тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарим зүйл, хэсгийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланд дурдсан санал, дүгнэлтэд тулгуурлан тус шаардлагыг хангаж буй эсэхийг үнэлнэ
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах
4	Зардал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үйлчлэлд хамаарах этгээдийн зардлыг тооцон гаргах

5	Харилцан уялдаа	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1, Аргачлалын 4 дүгээр зүйлийн 4.10-т заасан шаардлага хангасан эсэх
---	-----------------	---	---

3.1.Зорилгод хүрэх байдал

3.1.1.Зорилгыг тодорхойлох

Үзэл баримтлалд дурдсан үндэслэл, практик шаардлага, зохицуулалтын шийдэлд тулгуурлан хуулийн төслийн үндсэн зорилгыг дараах 4 багцад хуваах боломжтой байна:

- Бага үнийн дүнтэй хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг үр ашигтай, богино хугацаанд явуулж, шүүхийн хүртээмжийг нэмэгдүүлэх.
- Нэг шүүгчид ногдох хэргийн хэт ачааллыг “зохиомлоор өсгөдөг” буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ /цаашид “ХХДХ” гэх/ нэмэгдэх бүрд босго автоматаар өсдөг механизмыг арилгах, нөөцийг оновчтой хуваарилах.
- Мэдэгдэх хуудас гардуулах ажиллагааны үр дүн хангалтгүй байгаагийн шалтгаан болох шуудан, бичиг хүргэлтийн бодит чадамж, e-mongolia цахим шуудангийн доголдол, иргэдийн gmail ашиглалтын хэвшил сул зэрэг байдлыг засаж, оновчтой шийдлийг тодорхойлох.
- Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд үүсдэг гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах, гэрээнээс татгалзах зэрэг нэхэмжлэлээс үүдэн хэрэг хянан шийдвэрлэх хугацааг сунгаж, шүүхийн ачааллыг нэмэгдүүлдэг байдлыг хязгаарлах.

3.1.2.Зорилгод хүрэх байдалд дүн шинжилгээ хийх

Зорилгод хүрэх байдлыг үнэлэхэд тухайн зохицуулалт юуг өөрчилж, тэр нь ямар үр дүнг бий болгож, зорилтот үр дагаварт хэрхэн хүргэх вэ гэдгийг тогтоох шаардлагатай.

Хүснэгт-2

Өөрчлөлт	Зохицуулалт	Үр дүн	Зорилтот үр дагавар
Нэхэмжлэлийн үнийн дүнгийн босгыг тогтмол мөнгөн дүнгээр тогтооно.	75 ¹ дүгээр зүйлийн 75 ^{1.1} дэх хэсгийн “Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс” гэснийг “Арван таван сая төгрөгөөс” гэж өөрчилсөн.	• Тусгайлсан журмын хамрах хүрээ тогтвортой болно. • ХХДХ нэмэгдэх нь шүүхийн харьяалах хэрэг огцом нэмэгдэхэд хүргэдэг бөгөөд босго үнэ тогтоож өгснөөр	• Нэг шүүгчид ногдох хэргийн ачаалал “гадаад хүчин зүйл” /ХХДХ/-ээс шалтгаалан өсдөг нөхцөл байдал арилна. Улмаар хэрэг хянан шийдвэрлэх хугацаа богиносж, иргэдэд үзүүлэх

		өсөлтийн шалтгаан тасарна.	үйлчилгээний хүртээмж сайжирна.
Мэдэгдэх ажиллагааг шүүхийн албан ёсны цахим хуудсаар зарлан мэдээлэх механизмыг бий болгоно.	75 ⁴ дүгээр зүйлийн 75 ^{4.4} дэх хэсгийн “бол мэдэгдэх хуудсыг хүлээн авсанд тооцно.” гэснийг “боловч шүүхэд ирээгүй бол шүүхийн албан ёсны цахим хуудсаар нэхэмжлэгч, хариуцагчийн нэр, овог, нэхэмжлэлийн шаардлага болон хувийн ба үндэсний цахим шуудангийн хаягаар нь мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн тухай дурдан, шүүхэд хүрэлцэн ирж эрхээ хамгаалахаар ажиллагаанд оролцохыг зарлан мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдсэнээс хойш 7 хоног өнгөрсөн бол мэдэгдэх хуудсыг хүлээн авсанд тооцож хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэн явуулна.” гэж өөрчилнө.	- Мэдэгдэх хуудас “эзэндээ хүрээгүй” гэх шалтгаанаар шүүхийн тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа доголддог бус олон нийтэд ил тод зарлах замаар мэдэгдэл хүргүүлсэнд тооцож, маргааныг хянан хурдан шуурхай шийдвэрлэх боломж бүрдэнэ. - Шуудангийн үйлчилгээний гүйцэтгэл сул, бичиг хүргэгчийн тоо хүрэлцээгүй, e-mongolia системийн file/хэмжээ/ хүндрэл зэрэг асуудлаас үүдэн гарах асуудлыг шийдвэрлэх боломж бүрдэнэ.	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа багсаж, талууд өөрсдийн зөрчигдсөн эрхээ сэргээлгэхэд хугацаа алддаг байдал арилгана.
Хялбар ажиллагааны шүүх хэрэг хянан шийдвэрлэхэд талуудын зүгээс хугацаа хожих байдлыг хязгаарлах.	75 ¹ дүгээр зүйлд дараах агуулга бүхий 75 ^{1.6} дахь хэсэг нэмнэ. “Нэхэмжлэл ийн шаардлагаа энэ хуулийн 75^{1.1}-д заасан гэрээний үндэслэлээр тодорхойлсныг	Гэрээний үндсэн дээр үүссэн маргаантай холбогдуулан гэрээнээс татгалзсан, эсхүл хэлцэл хүчин төгөлдөр бус зэрэг үндэслэлээр эсэргүүцэн	“Хурдан, шуурхай шийдвэрлэх” зорилгод нийцэх бөгөөд талууд эрх, хууль ёсны ашиг сонирголоо шүүхээр хамгаалуулахад хугацаа алддаг байдал багасна.

	гэрээнээс татгалзсан, эсхүл хэлцэл хүчин төгөлдөр бус гэх үндэслэлээр эсэргүүцэн маргасан нь тус хэргийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэхэд саад болохгүй.”	маргаснаар ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжиж, хугацаа алддаг байлыг арилгана.	
Барьцааны зүйлээс үндсэн үүргийг хангуулах маргааныг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэхэд 75 ¹ дүгээр зүйлийн үнийн дүнг харгалзан үзнэ.	75 ¹ дүгээр зүйлийн 75 ^{1.1} дэх хэсэгт дараах агуулга бүхий 75 ^{1.1.5} дахь заалт нэмнэ. • Энэ хуулийн 75 ^{1.1} -д заасан үнийн дүн бүхий үндсэн үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах.”	• Барьцаатай холбоотой тодорхой төрлийн мөнгөн шаардлагыг /15 сая төгрөгийн босго дотор/ түргэн шуурхай шийдвэрлэх нөхцөл бүрдэнэ.	Нэхэмжлэгч талын эрх ашгийг шуурхай хамгаалах боломж нэмэгдэнэ.
Давж заалдах шатны шүүх тус маргааны эцсийн шийдвэрийг гаргах	“75 ¹¹ дүгээр зүйлийн 75 ^{11.2} дахь хэсгийг “Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг давж заалдах шатны шүүх эцэслэн шийдвэрлэх ба хяналтын журмаар гомдол гаргахгүй.” гэж өөрчлөн найруулна.	Давж заалдах шатны шүүх хэрэг, маргааныг эцэслэн шийдвэрлэснээр процессийн хугацаа богиносно.	• Хялбаршуулсан ажиллагааны гол зорилго болох “богино хугацаанд хэрэг маргааныг шийдвэрлэх” байдал бодитоор нэмэгдэнэ. • Шүүхийн ачаалал багасна.

Дүгнэлт

1.Үзэл баримтлалд дурдсан практик асуудлууд харгалзан үзвэл 15 сая төгрөгөөр босго тогтоох нь шүүхийн ачааллын “зохиомол өсөлт”-ийг сааруулж, тогтвортой байдлыг бий болгох замаар дээр тодорхойлсон зорилгод нийцэхээр байна.

2.Мэдэгдэх ажиллагаанд шүүхийн албан ёсны цахим хуудсаар зарлах механизм нэмэх нь “гардуулалт хангалтгүй” гэсэн бодит шалтгаанд чиглэж байгаа

тул зорилгод нийцэх үндэслэлтэй боловч түүнийг хэрэгжүүлэхэд тодорхой стандарт шаардлагатай гэж үзэж байна.

3.75¹ дүгээр зүйлийн 75^{1.6} дахь хэсэг болон 75^{1.1} дэх хэсгийн 75^{1.1.5} дахь заалт нь тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны үр ашиг, шуурхай байдлыг нэмэгдүүлэх замаар зорилгод нийцэхээр байна. Гэвч барьцаатай холбогдсон маргааны нарын төвөгтэй байдал нэмэгдэхэд тус зорилго биелэх эсэхэд дүн шинжилгээ хийж 75⁷ дугаар зүйлтэй уялдуулан практикт зөв хэрэгжүүлэх шаардлага үүсэхээр байна.

4.75¹¹ дүгээр зүйлийн 75^{11.2} дахь хэсгийг давж заалдах шатны шүүх хэрэг маргааныг эцэслэхээр өөрчлөн найруулснаар хэрэг хянан шийдвэрлэх хугацааг бодитоор багасгах боломжтой тул зорилгод нийцнэ, харин шударга шүүхээр шүүлгэх эрхтэй нийцэх эсэхийг хуулийн төслийн үзэл баримтлал болон танилцуулга, холбогдох бусад судалгаагаар нотлох шаардлагатай.

Иймд “Зорилгод хүрэх байдал” шалгуурын хүрээнд төслийн үнэлгээ нь ерөнхийдөө эерэг (дунд-өндөр) гэж дүгнэж болохоор байна.

3.2.Практикт хэрэгжих боломж

3.2.1.Хэрэгжүүлэгч субъект, институцийн чадавх

Хэрэгжүүлэгч байгууллага: Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхүүд, шүүхийн Тамгын газар, шүүгч, шүүх хуралдааны нарийн бичиг, бичиг хэрэг, мэдээлэл технологийн ажилтан.

Үзэл баримтлал, зардлын тооцоонд тулгуурласан үнэлгээ

Мэдэгдэх ажиллагааг баталгаат шуудан, бичиг хүргэлт, үндэсний цахим шуудан зэргээр хүргэж байгаа боловч бодит үр нөлөө хангалтгүй байгаа дараах шалтгаанууд байна. Үүнд:

- Шуудангийн гардуулалт сул;
- Бичиг хүргэгчийн хүрэлцээ бага;
- e-mongolia системийн файл/хэмжээ/саатлын хүндрэл;
- Иргэдийн и-мэйл хэрэглээний хэвшил сул гэх мэт.

Иймээс “шүүхийн албан ёсны цахим хуудас”-аар зарлан мэдээлэх замаар мэдэгдэх хуудас хүргэсэнд тооцож, хүндрэлүүдийг багасгах нь практикт хэрэгжих боломжтой шийдэл гэж үзэж байна.

Шүүхүүд албан ёсны цахим хуудастай байдаг тул шинэ систем худалдан авах зэрэг хөрөнгө оруулалт шаардалгүйгээр хэрэгжих бүрэн боломжтой байх тул суурь нөхцөл бүрдсэн гэж үзэхээр байна.

Дараах эерэг нөлөө үүснэ

Шуудан, бичиг хүргэлтээс хамаарал багассанаар Тамгын газрын “давтан хүргэлт”, “буцаалт”, “шүүх хурлыг хойшлуулах” зэрэг асуудлууд багасах боломжтой.

75¹¹ дүгээр зүйлийн 75^{11.2} дахь хэсэгт оруулах өөрчлөлтөөр тусгайлсан журмаар шийдвэрлэсэн хэргийг давж заалдах шатанд эцэслэн шийдвэрлэх хууль зүйн орчин бий болсоноор хяналтын шатны шүүхийн ачаалал буурна.

Хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардагдах зохион байгуулалтын арга хэмжээ

- Шүүхийн цахим хуудсаар зарлан мэдээлэх стандарт ажиллагааны журам зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна. Тодруулбал, ямар мэдээллийг нийтлэх, ямар хугацаанд, ямар форматаар, ямар баталгаажуулалттайгаар нийтлэхийг нэг мөр болгож, нийтэлсэн огноо, цаг, засварласан түүх, устгалын бүртгэл зэрэг мэдээллийг хадгалах.
- И-мэйл хаягаар хүргүүлсэн тохиолдолд нотолгоо бүрдүүлэх. Тухайлбал, илгээсэн тухай, буцсан эсэх, хүргэгдсэн тэмдэглэл зэргийг хэргийн материалд нэг мөр хавсаргах.
- Өгөгдлийн хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдалтай холбогдуулан нийтлэх мэдээллийн хүрээг хязгаарлах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, хамгийн бага шаардлагатай мэдээллийг нийтлэх нь зүйтэй. Мөн кибер халдлага болон бусад эрсдэлт нөхцөл байдлаас шалтгаалан мэдээлэл алдагдахаас сэргийлэх хяналтын тогтолцоог бий болгох нь зүйтэй байна.

Дүгнэлт

Хуулийн төслийн практикт хэрэгжих боломжийг “Дунд-өндөр” гэж үнэллээ. Учир нь шинэ тогтолцоог “0-ээс босгох” бус, одоо байгаа процессын сул талыг арилгах, нөхөх шинжтэй зохицуулалтуудыг тусгаж өгсөн байна. Гэвч дээр дурдсан хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардагдах зохион байгуулалтын арга хэмжээг авах шаардлагатай байна.

3.3.Ойлгомжтой байдал

Хуулийн төслийн нэр томьёо, найруулга нь хэрэглэгчдэдээ ойлгомжтой эсэхийг үнэлэв.

Тодорхой байдал: “Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс” гэх хувьсах хэмжигдэхүүнийг “Арван таван сая төгрөгөөс” гэж тогтмол тоон утгаар сольсон нь иргэн, хуулийн этгээдэд маш ойлгомжтой, хоёрдмол утгагүй болсон. Хэн, аль шүүхэд хандахаа мэдэхэд хялбар болно.

Процессын дараалал: Мэдэгдэх хуудас хүргүүлэх дарааллыг дараах байдлаар тогтоосон байна. Үүнд:

- 1.“шүүхэд ирээгүй бол”
- 2.“цахим хуудсаар мэдэгдэх”
- 3.“7 хоног хүлээх”
- 4.“хүлээн авсанд тооцох”

Дээрх байдлаар логик дараалалтай, алхам алхмаар тодорхой заасан нь хууль хэрэглээний явцад салаа утгаар ойлгогдохгүй байх нөхцөлийг хангасан байна.

Нэр томьёо: “Хувийн ба үндэсний цахим шуудан” гэж тодотгосон нь иргэний өдөр тутам ашигладаг и-мэйл хаягийг хамруулж байгааг ойлгомжтой илэрхийлсэн байна

Иймд ойлгомжтой байдлын шалгуурыг хангасан “Сайн” гэж үнэлэж байна.

3.4.Зардал

Энэхүү хуулийн төслийг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс нэмэлт санхүүжилт шаардагдахгүй. Харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цахимжилтыг дэмжих, шат дамжлагыг цөөлөх замаар шүүхийн үйл ажиллагааны зардлыг бууруулах, иргэд, хуулийн этгээдийн шүүхэд зарцуулах цаг хугацаа, хөрөнгийг хэмнэх эдийн засгийн эерэг үр нөлөөтэй байна гэж дүгнэлээ.

3.5.Харилцан уялдаа

Тус хуулийн төсөл нь дотоод уялдаа сайтай байна. Тухайлбал, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.4 дэх заалтад 75⁷.1-т заасан үндэслэл тогтоогдвол хэмээн нэмж, 75⁷ дугаар зүйлийн 75⁷.1 дэх хэсэгт “өөр шүүхэд шилжүүлж болно” гэж өөрчилж байгаа нь логикийн хувьд уялдаатай байна.

Бусад хууль тогтоомжтой уялдах тал дээр төслийн гол зохицуулалтууд нь Үндсэн хуулийн “шударга шүүхээр шүүлгэх, шүүхэд гомдол гаргах” эрхийн баталгааг бодитой болгох зорилготой нийцэж байгаа боловч 75¹¹ дүгээр зүйлийн 75¹¹.2 дахь хэсэгт тусгайлсан журмаар хянан шийдвэрлэсэн хэрэг, маргааныг давж заалдах шатанд эцэслэж, хяналтын журмаар гомдол гаргах эрхийг хаасан нь “давж заалдах эрхийн баталгаа”-тай холбогдсон маргааныг үүсгэх эрсдэлтэй тул үзэл баримтлал, танилцуулгаар тодорхой үндэслэх шаардлагатай.

Түүнчлэн 75⁴ дүгээр зүйлийн 75⁴.5 дахь хэсэгт заасан шүүхийн цахим мэдээллийг зүй бусаар ашиглахыг хориглосон зохицуулалт нь нэр төр, хувийн орон зай хамгаалах зорилготой уялдах боловч хэрэгжилтийн хувьд холбогдох хариуцлага, хэрэгжүүлэх журамтай хэрхэн уялдахыг тодорхойлж өгөөгүй байна.

Иймд төслийн харилцан уялдааны ерөнхий үнэлгээ “дунд-сайн” гэж үнэллээ.

4.ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ЭЦСИЙН ДҮГНЭЛТ

Энэхүү хуулийн төсөл нь бага үнийн дүнтэй хэрэг, маргааныг хурдан, шуурхай шийдвэрлэх, шүүхийн ачааллыг бууруулах, мэдэгдэх хуудас гардуулах ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх үндсэн зорилготой бөгөөд тус зорилго нь үзэл баримтлалд дурдсан практик хүндрэлүүдтэй шууд уялдсан байдлаар тодорхойлогдсон байна.

Төслийн гол шийдлүүд нь тусгайлсан журмын босгыг 15,000,000 төгрөгөөр тогтмол тогтоох, 75⁴ дүгээр зүйлийн 75⁴.4 дэх хэсэгт шүүхийн албан ёсны цахим хуудсаар зарлан мэдээллэж 7 хоногийн дараа мэдэгдсэнд тооцох механизмыг бүрдүүлэх, 75¹ дүгээр зүйлийн 75¹.6 дахь хэсэгт “гэрээ хүчин төгөлдөр бус, эсхүл гэрээнээс татгалзсан” гэх шалтгаанаар тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоохгүй байх, хэрэг шилжүүлэх боломжийг 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.4 дэх заалтыг 75⁷ дугаар зүйлийн 75⁷.1 дэх хэсэгтэй холбон сайжруулах, мөн 75¹¹ дүгээр зүйлийн 75¹¹.2 дахь хэсэгт заасан тусгайлсан журмаар хянан шийдвэрлэсэн хэрэг давж заалдах шатанд эцэслэгдэх зохицуулалтууд болно.

Тус зохицуулалтууд нь бүхэлдээ процессын хугацааг богиносгох, нөөцийг оновчтой хуваарилах замаар шүүхийн үйлчилгээний хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бөгөөд тус зорилгодоо хүрэх боломжтой гэж үзэж байна.

Зардлын хувьд төсөл нь иргэн, хуулийн этгээдэд шинэ татвар, төлбөр, хураамж бий болгохгүй, харин мэдэгдэх ажиллагааг цахимаар явуулах нөхцөл байдлыг бүрдүүлсний үр дүнд шүүхийн байгууллагын шуудан хүргэлтийн урсгал зардлыг бууруулах, иргэд, аж ахуйн нэгжийн хугацаа алддаг байдал, өмгөөллийн болон төлөөллийн зардлыг багасгах эерэг үр нөлөө үзүүлэхээр байна.

Иймд нийт үнэлгээгээр хуулийн төслийн үр нөлөө “ерөнхийдөө эерэг”, хэрэгжих боломж “дунд-өндөр” гэж дүгнэж болох бөгөөд зорилгодоо хүрэх, үр ашигтай байх бүрэн боломжтой байна.